213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	51,469,944

2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	51,469,944
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		22,069,944
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		29,400,000
2133	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	6,350,960	2,549,100
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	6,350,960	2,549,100
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	77,771,960	192,551,395.4
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	77,771,960	192,551,395
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	900,000	-
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,668,598	31,500,000
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	45,732,875	64,195,635
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,470,487	9,807,260.4
131106	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	-	87,048,500

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дөргөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд авлага, шатахууны зарцуулалт, дотоод хяналт, зээлийн эргэн төлөлт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор Д.Нарантуул 2022 оны 3 дугаар сарын 17-ноос 2022 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Дөргөн сумын Засаг дарга 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 1/63 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дөргөн сумын засаг дарга нь “Хүний хөгжлийг эрхэмлэн иргэдийнхээ ажиллаж амьдрах эрүүл, аюулгүй таатай орныг бүрдүүлэн, төрийн үйлчилгээг иргэдэд тэгш хүртээмжтэй хүргэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй хүндрэлийг даван туулах
- Хүний хөгжил, нийгмийн харилцааны бодлого
- Эдийн засаг, хөдөө аж ахуйн бодлого
- Засаглалын бодлого
- Байгаль орчин, аялал жуулчлал
- Дэд бүтэц, газар зохион байгуулалт, төлөвлөлтийн бодлого

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Малын тоо толгойн албан татварын тухай хууль*
- *Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль*
- *Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль*
- *Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай*
- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.

Сумын нэгтгэсэн санхүүгийн тайланд мөрдөх тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн и-баланс цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

Дөргөн сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд 2021 оны 03 дугаар сард дотоод хяналт хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дөргөн сумын ТТЗ-ын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зарлагын 3,133.1 сая төгрөгөөс 2 хувиар тооцон 62.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 50.1 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дөргөн сумын ТТЗ-ын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 673.3 сая төгрөгөөр буюу 12 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, цэвэр өмчийн дансдууд байна.

Хүснэгт №1. Санхүүгийн байдлын тайлан /сая. төгрөг/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
Мөнгөн хөрөнгө	83.2	137.0	-53.80	165%
Авлага	355.2	400.5	-45.35	113%
Бараа материал	209.5	237.4	-27.85	113%
Үндсэн хөрөнгө	5,119.5	5,665.8	-546.35	111%
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,767.4</b>	<b>6,440.7</b>	<b>-673.35</b>	<b>112%</b>
Богино хугацаат өр төлбөр	7.3	6.4	0.90	88%
Цэвэр хөрөнгө, өмч	5,760.1	6,434.3	-674.20	112%
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>5,767.4</b>	<b>6,440.7</b>	<b>83,525.21</b>	<b>112%</b>

Эх сурвалж: Дөргөн сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 83.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 137.0 сая төгрөг болж 53.8 сая төгрөгөөр буюу 65 хувиар өссөн байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 137.0 сая төгрөг нь Төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

#### 3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 400.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 400.5 сая төгрөг болж 45.3 сая төгрөг буюу 13 хувиар өссөн байна.

Хүснэгт 2: Авлагын үлдэгдэл

сая. төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.04	2.5	2.5
Төлбөртэй үйлчилгээний авлага		26.0	26.0
Байгууллагаас авах авлага	0.91	0.7	(0.2)
Хувь хүмүүсээс авах авлага	2.80	2.6	(0.2)
Зээлийн хүүгийн авлага	257.2	227.9	(29.3)
Татвар, НДШ /ОНӨААТҮГ/		1.8	1.8
Татаас санхүүжилтийн авлага	6.4		(6.4)
<b>Дүн</b>	<b>267.3</b>	<b>261.5</b>	<b>(5.7)</b>
Урьдчилж гарсан зардал		10.0	10.0
Тусгай зориулалтын сан	87.3	115.5	28.2
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа		13.0	13.0
Цалингийн урьдчилгаа	0.6	0.5	(0.1)
<b>Дүн</b>	<b>87.9</b>	<b>139.0</b>	
<b>АВЛАГЫН НИЙТ ДҮН</b>	<b>355.2</b>	<b>400.5</b>	<b>(5.7)</b>

Эх сурвалж: Дөргөн сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд 158.6 сая төгрөгийн насжилт өндөртэй байгаа авлагын дийлэнхийг сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн авлага эзэлж байгаа бөгөөд оны эхэнд 257.2 мянган төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй байсан ба тайлант зээл олгоогүй, 39.7 сая төгрөгийн зээл, зээлийн хүү эргэн төлөгдөж, оны эцэст 227.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

ОНХС-гийн авлагад бүртгэлтэй хашааны авлагын эхний үлдэгдэл 87.3 сая төгрөгөөс тайлант онд 34.8 сая төгрөгийн авлагыг барагдуулж 63.0 сая төгрөгийг малжуулах төсөлд, 10.0 сая төгрөгийг урьдчилж олгосон зардлаар олгон 125.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

### **3.5.3 Бараа материал**

Бараа материалын дансны үлдэгдэл 237.4 сая төгрөг болж 27.8 сая төгрөгөөр өссөн нь 55.9 сая төгрөгөөр эм боох материал, аж ахуйн материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсантай холбоотой нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 285.1 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, үнэ төлбөргүйгээр 55.9 сая төгрөгөөр нийт 341.0 сая төгрөгөөр нэмэгдэж, 313.2 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

### **3.5.4 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 6,625.3 сая төгрөг байсан бол оны эцэст 7,685.4 сая төгрөг болж 1,060.1 сая төгрөгөөр өссөн нь 23.6 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авсан, 684.1 сая төгрөгөөр хандив, бусад, сумын ЗДТГ-ын өмнөх онд барилга байгууламжийн үлдэгдлийг буруу тооцсонтой холбоотой 249.8 сая төгрөгөөр шилжүүлэн авсан холбоотой байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө 23.6 сая төгрөгөөр төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн, 943.8 сая төгрөгөөр шилжүүлэн авсан, үнэ төлбөргүй хандиваар нэмэгдэж, акталсан, балансаас балансад шилжүүлсэн 137.2 сая төгрөгөөр хөрөнгө хасагдсан байна.

### **3.5.6 Өр төлбөр**

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 7.3 сая, эцсийн үлдэгдэл 6.4 сая төгрөг болж 0.9 сая төгрөгөөр буурсан байна. Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 6.4 сая төгрөгийн өр байгаа нь дараа тайлангийн хугацаанд бүрэн барагдах боломжтой өглөгүүд байна.

Үүнээс: Ажилчидтай холбоотой өглөг 0.1, бараа үйлчилгээний өглөг 3.1, байгууллагад өгөх өглөг 2.2, хувь хүмүүст өгөх өглөг 0.9 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэл байна.

### **3.5.7 Цэвэр хөрөнгө, өмч**

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 5,760.1 сая төгрөг байсан оны эцэст 6,434.3 сая төгрөг тайлант онд 674.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 426.5 сая төгрөгийн ашигтайтай, өмнөх үеийн үр дүн рүү 247.8 сая төгрөгөөр залруулсантай холбоотой байна.

## **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,726.3 сая төгрөгөөр, нийт зарлагыг 2,726.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дэргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн төсвийг аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03 өдрийн 3/03 тоот тогтоолоор 2,579.9 сая төгрөгөөр анх баталж өмнө оны болон тайлант оны орлого давсан холбоотойгоор 2021 онд 1 удаа тодотгол хийн 2021 оны 08 дугаар сарын 05-ны 4/03 тоот тогтоолоор нийт 2,728.8 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголыг сумын ИТХ-аар 2021 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн Б/02 тоот тогтоолоор 2,728.8 сая төгрөгөөр 6 байгууллага, 2 сангийн төсвийг тодотгож баталжээ.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 2,728.8 сая төгрөгийн төсөв баталснаас 1,732.9 сая төгрөгийг улсын төсвөөс, 753.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 24.4 сая төгрөгийг ЭМДС-аас, 127.2 сая төгрөгийг ОХНС-аас санхүүжих, 0.6 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 50.3 сая төгрөгийг туслах үйл ажиллагаанаас, 40.1 сая төгрөгийг өмнөх оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Хүснэгт 3: Төлөвлөгөө, гүйцэтгэл	сая. төгрөг	төлөвлөгөө	гүйцэтгэл
Улсын төсвөөс санхүүжих		1,732.9	1,699.9
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		1,732.9	1,699.9
Орон нутгийн төсвөөс санхүүжих		880.5	810.9
Орон нутгийн төсвөөс		753.3	684.7
Орон нутгийн хөгжлийн сан		127.2	126.2
Нийгмийн даатгалын төсвөөс санхүүжих		24.4	19.2
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		24.4	19.2
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		91.0	77.3
Үндсэн үйл ажиллагааны орлогоос		0.6	0.6
Туслах үйл ажиллагааны орлогоос		50.3	76.7
Урьд оны үлдэгдлээс санхүүжих		40.1	
<b>ЭХ ҮҮСВЭРИЙН НИЙТ ДҮН</b>		<b>2,728.8</b>	<b>2,607.3</b>

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,699.8, орон нутгийн төсвөөс 684.7, ОХНС-ийн санхүүжилт 126.2, ЭМДС-аас санхүүжих 19.3, үндсэн үйл ажиллагааны орлогоос 0.6, туслах үйл ажиллагааны орлогоос 76.7 сая төгрөг нийт 2,607.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,569.9 мянган төгрөгийг зарцуулж 33.1 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,569.9 сая мянган төгрөг буюу 94.2 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 24.0 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 4.5, бараа хангамж, бараа материалын зардал 0.4, томилолтын зардал 2.6, нормативт зардал 23.7, бараа үйлчилгээний бусад зардал 20.1, хөрөнгийн зардал 33.2, эргэж төлөгдөх зээл 50.0 сая төгрөгөөр буюу нийт 158.9 сая төгрөгөөр батлагдсан төсвийг хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 0.6, туслах үйл ажиллагааны орлого 50.3 сая төгрөгөөр тус тус батлагдаж гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогыг 0.6 сая, туслах үйл ажиллагааны орлогыг 76.7 сая төгрөгөөр нийт 77.3 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн. Нийт бүрдүүлсэн орлогын 41.5 сая төгрөгийг СХС-ийн зээл, зээлийн хүүгийн орлого, 34.8 сая төгрөг нь малжуулах төслийн эргэн төлөлт, 0.3 сая төгрөг нь ЕБС-ийн өөрийн орлого бүрдүүлэн төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогыг 26.4 сая төгрөгөөр давуулж биелүүлж 31.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Дэргэн сумын ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 2021 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн Б/02 дугаар тогтоолд Дэргэн сумын Төвлөрүүлэн захирагчийн тайлант онд 68.5 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр

батлагдсанаас гүйцэтгэлээр 87.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 128.3 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 4. Сумын татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая.төгрөг/

Орлогын ангилал	2021 оны		Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Татварын нийт орлогын дүн	68.5	87.9	(19.4)
Нийт орлого ба тусламжийн дүн	68.5	87.9	(19.4)
Татварын орлого	66.5	86.5	(16.9)
Орлогын албан татвар	8.0	18.5	(10.5)
Хувь хүний орлогын албан татвар	8.0	18.5	(10.5)
Үйл ажиллагааны орлого	14.7	18.2	(3.5)
Хөрөнгийн албан татвар	20.9	21.4	(0.5)
Бууны албан татвар	0.9	1.0	(0.1)
Иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого	20.0	20.4	(0.4)
Малын тоо толгойн албан татвар	16.0	22.4	(6.3)
Малын тоо толгойн албан татвар	16.0	22.4	(6.3)
Бусад татвар, төлбөр, хураамж	3.4	3.0	0.4
Улсын тэмдэгтийн хураамж	2.0	1.6	0.3
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны	5.0	5.0	-
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1.0	1.2	(0.2)
Газрын төлбөр	1.7	1.6	0.1
Газрын төлбөр	1.7	1.6	0.1
Байгалийн нөөц ашигласны төлбөр	1.7	1.4	0.2
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	1.1	1.1	-
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	0.6	0.4	0.2
Татварын бус орлого	2.0	1.4	0.6
Нийтлэг татварын бус орлого	2.0	1.4	0.6
Торгуулийн орлого	2.0	1.4	0.6

Эх сурвалж: Дэргэн сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт орлого 87.9 сая төгрөг буюу 19.4 сая төгрөгөөр давуулжээ. Орлого давсан шалтгаан нь хувь хүний орлогын албан татвар 10.5, хөрөнгийн албан татварын орлого 0.5, үйл ажиллагааны орлого 3.5, малын тоо толгойн орлого 6.3 сая төгрөгөөр давуулан биелүүлж улсын тэмдэгтийн хураамж 0.3, газрын төлбөр 0.1, байгалийн нөөц ашигласны төлбөр 0.2, татварын бус орлого 0.6 сая төгрөгөөр тасалжээ.

Татварын бус орлого тасрах үндсэн шалтгаан нь СХС-гийн орлогыг 50.0 сая төгрөгийн орлого төлөвлөснөөс 41.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж 8.5 сая төгрөгөөр тасалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн тайлангаар Хөшөөт хөгжлийн сангаас 31.5, ЭМДС-аас Ковид-19 цар тахлын илүү цаг урамшуулал, эмийн зардалд 114.0, өмнөх оны авлага буюу татан төвлөрүүлэлтээс 6.3, БСУГ-аас ЕБС болон СӨБ-ийн байгууллагад ажиллаж байгаа багш нарын тэтгэмж 22.1, номын түрээсийн орлого 2.6, Статистикийн газраас судалгааны зардал 1.1, гадаадын төслөөс 8.0, бусад орлогоос 7.0 сая төгрөг нийт 192.6 сая төгрөгийн орлого бүрдүүлэн 190.1 сая төгрөгийг зарцуулж орон нутгийн төсөвт 2.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Дөргөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай дараах асуудлууд байна. Үүнд:

1. Сум хөгжүүлэх сангаас 2011-2020 онуудад олгосон 43 зээлдэгчийн 308.2 сая төгрөгийн зээл олгогдсоноос 3 иргэн нас барсан, 15 зээлдэгч зээл бүрэн төлж дууссан, 7 иргэний 31.9 сая төгрөгийн зээлийн төлөх хугацаа болоогүй, 21 иргэний 149.1 сая төгрөгийн мянган төгрөгийн зээлийн авлага нь хугацаа хэтэрч байгаа нь сангийн хөрөнгийн эргэцийг удаашруулж, хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.
2. “Жигүүр ажнай” ХХК-тай 15 жилийн хугацаатай концессийн гэрээ байгуулан сумын төсөвт байгууллагуудыг халаалт дулаанаар ханган ажиллаж тайлант онд өр төлбөр үүсээгүй тайлагнасан ч төсөвт байгууллагуудад батлагдсан төсвөөр гэрээ байгуулан зардлыг санхүүжүүлсэн байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Дөргөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд УТХО-оор 499.0 сая төгрөгийн өртөг бүхий ахуй үйлчилгээний байрны их засварын ажлыг “Зөөлөн тэмүүлэл ХХК” гүйцэтгэж, данс бүртгэлд тусгасан, сумын Эрүүл мэндийн төв Ковид-19 цар тахлын үйлчилгээ үзүүлсний төлбөрт ЭМДС-аас авах 26.0 сая төгрөг, ОНХС-аас Стандарт ховд хөтөлбөрийн хүрээнд 10.0 сая төгрөгийг урьдчилж төлсөн, тайлант онд 9 иргэнд малжуулах төслөөс 63.0 сая төгрөгийн зээл олгосонтой холбоотой авлага үүссэн асуудлууд нь үлэмж нөлөө үзүүлсэн байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 157 мэдээллээс 148 хугацаандаа оруулсан 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Аймгийн хэмжээнд сум хөгжүүлэх сангийн Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг мэдээлэх тусгай цэсгүйгээс тайлант онд орсон орлогын гүйлгээг мэдээлээгүй, зарлагын гүйлгээ гаргаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 83.6 сая төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж өгөгдсөн бөгөөд 75 хувьтай хэрэгжүүлсэн байна.

#### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Ковид-19 цар тахал, Шүлхий өвчинтэй холбоотой сумын төсөвт байгууллагуудаас гаргасан зардлын зарцуулалт, малжуулах төсөлд хамрагдах иргэдийн

сонгон шалгаруулалт ил тод нээлттэй эсэх, олгосон санхүүжилтийн асуудлыг авч үзэх нь зүйтэй байна.

### 3.12 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагыг аудитад хамруулан дүгнэлт гаргаж, 5 тайланг түүвэрт хамруулсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”-2 (сумын 12 жилийн сургууль, сумын хүүхдийн цэцэрлэг), “Хязгаарлалттай” 1 (ЭМТөв) нийт 3 дүгнэлт гаргасан байна.

Дөргөн сумын ТТЗ-ын нэгтгэлд хамрагдсан төсвийн шууд захирагчдын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 192.6 сая төгрөгийн 16 алдаа зөрчил илэрч, 24.7 мянган төгрөгийн 6 алдааг залруулсан байна.

Залруулагдаагүй 167.9 сая төгрөгийн алдаа зөрчлөөс 1.9 сая төгрөгийн алдаа зөрчилд 3 төлбөрийн акт тогтоон, 2.9 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгуулах 1 албан шаардлага өгч, 163.2 сая төгрөгийн 6 алдаа зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна. Нийт алдаа зөрчил, шийдвэрлэлтийг хүснэгтээр харуулбал: Хүснэгт -5 /сая.төг/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дөргөн сумын 12 жилийн сургууль	3	106.6	1	0.7					2	105.9
2	Дөргөн сумын хүүхдийн цэцэрлэг	4	0.8	1	0.1	1	0.8			2	
3	Дөргөн сумын ЭМТ	9	85.2	4	23.9	2	1.1	1	2.9	2	57.3
	<b>Дүн</b>	<b>16</b>	<b>192.6</b>	<b>6</b>	<b>24.7</b>	<b>3</b>	<b>1.9</b>	<b>1</b>	<b>2.9</b>	<b>6</b>	<b>163.2</b>

Эх сурвалж: Дөргөн сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

## 4. Нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,070.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 751.7 сая төгрөгийн алдааг залруулж, 1.9 сая төгрөгийн 2 алдаа зөрчилд төлбөрийн акт, 149.1 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 168.2 сая төгрөгийн 5 зөвлөмж өглөө.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. ОНХС-ийн тайланд авлага, тайлант үеийн үр дүн зөрүүтэй тайлагнасан 20.0 сая төгрөг,
2. Сумын ИТХ-ын санхүүгийн тайланд өмнөх оны хуримтлагдсан элэгдлийн зөрүү, тайлант оны хуримтлагдсан элэгдэл, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн тохируулах бичилт, тайлант үеийн үр дүнтэй холбоотой 9.9 сая төгрөг,
3. ЗДТГ-ын санхүүгийн тайланд акталсан хөрөнгийг дутуу хассан, барилга байгууламжийн өртөг, хуримтлагдсан элэгдлийг зөрүүтэй тусгасан, үнэ төлбөргүй нэмэгдсэн бараа материалыг бүртгээгүй зэрэгтэй холбоотой 714.0 сая төгрөг,

**Шийдвэрлэсэн нь:** Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 743.9 сая төгрөгийн залруулга хийж, залруулсан 2022 оны 03 дүгээр сарын 21-ны 1/69 тоот албан бичгээр санхүүгийн тайланд залруулга хийсэн болно.

### 4.2 Төлбөрийн акт

1. Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолоор айл өрхийн цэвэр бохир усны хөнгөлөлтөд 3.0 сая төгрөгийг сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан

цэвэр ус түгээдэг хүнтэй гэрээ байгуулан сар бүр 261 айл өрхөд ундны ус түгээж холбогдох зардалд 2.0 сая төгрөгийн олгож 1.0 сая төгрөгийг зориулалтын зарцуулсан илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулах” гэсэн хуулийн заалт, аудитын “Үнэн зөв байдал”, “Иж бүрэн” байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Сумын ИТХ-аас батлагдсан төсвийг зориулалт бусаар 0.9 сая төгрөгийг зарцуулсан зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт аудитын “үнэн зөв байдал”, “тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

#### 4.3 Албан шаардлага

4.3.1 1 Илрүүлэлт: СХС-ийн хөрөнгөөс 2011-2018 онуудад зээл олгогдож 73 зээлдэгч зээлээ олгогдож, зээлдэгчтэй байгуулсан гэрээний үүргээ биелүүлээгүй 21 зээлдэгчтэй холбоотой 149.1 сая төгрөгийн зээл, зээлийн хүүгийн хугацаа хэтэрсэн үлдэгдэлтэй, авлага барагдуулаагүй сангийн дансанд төвлөрүүлээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Зээлдэгчтэй байгуулсан гэрээний 7.2.4-д “Зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлнэ”, 8.2-д “Зээлдэгч зээлийн төлбөрийг сар бүрийн төлбөрийн хуваарийн дагуу төлнө”, 9.2-д “Зээлдэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй дараах тохиолдолд Зээлдүүлэгч гэрээг цуцалж, зээл, хүү нэмэгдүүлсэн хүүгийн төлбөрийг үл маргах журмаар төлүүлнэ. Үүнд: 9.2.1-д “Зээлийн гэрээний 3.2-т зааснаас өөр зориулалтаар ашигласан”, 9.2.2-д “Зээлийн гэрээгээр тохиролцсон хуваарийн дагуу төлбөрөө бүрэн төлөлгүй 60 хоног хугацаа хэтэрсэн”, 9.2.4-д “Гэрээгээр хүлээсэн үүргээ 2-оос дээш удаа зөрчсөн, эсвэл 15 дээш хоногоор хугацаа хэтрүүлсэн бол гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

#### 4.4. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 4.4.1 Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Дэргэн сумын ТТЗ-ын нэгтгэсэн санхүүгийн тайланд 34.9 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн, эзэн холбогдогч нь тодорхойгүй авлага бүртгэлтэй байхад авлагыг бууруулах чиглэлээр тодорхой ажлууд хэрэгжүүлээгүй байна. Үүнд: Сум хөгжүүлэх сангийн тайланд зээлийн гэрээнд заасны дагуу алданги тооцохдоо 6.1 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн, ЗДТГ-ын тайланд 1.9 сая төгрөгийн эзэн холбогдогч нь тодорхой бус авлага, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлсэн жишиг хашаа хөтөлбөрийн 26.9 сая төгрөгийн авлага нийт 34.9 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалт хэрэгжээгүй байна.

Өгсөн зөвлөмж Сумын ТТЗ-ын нэгтгэл тайланд авлагын үлдэгдлээр тайлагнасан хугацаа хэтэрсэн авлагуудыг бууруулах талаар үе шаттай арга хэмжээг авч хэрэгжүүлэн төсвийн хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлж ажиллах

##### 4.4.2 Шатахууны зарцуулалт, дотоод хяналттай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Орон нутгийн хөгжлийн сангаас Ковид-19 цар тахал, малын шүлхий өвчний гамшгийн үед 9.6, ИТХ тайлант онд 1.5, нийт 11.1 сая төгрөгийн шатахууныг зарцуулсан ч жолоочийн тооцоо бодоогүй, дотоод хяналт хэрэгжүүлээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын 1.3-д "аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-тай байна", 1.5-д "... Журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд "дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам" тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө" гэсэн заалтуудыг мөрдөөгүйтэй холбоотой байна.

**Өгсөн зөвлөмж:** Гамшгаас хамгаалах мөрдөх сангийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулах талаар анхааран ажиллах,

#### **4.4.3 Анхан шатны баримттай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Сумын ЗДТГазар, ИТХ, Соёлын төв 2021 онд 54.6 сая төгрөгийн бараа материал худалдан авахдаа бараа бүтээгдэхүүнүүдэд гарсан зардлуудыг баримтжуулахдаа и баримтаар баталгаажуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28.5-д "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсвэл цахимаар илгээх үүрэгтэй", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг хэрэгжилт сумын хэмжээнд хангалтгүй байна.

**Зөвлөмж:** Сумын төрийн сангаас зардлыг санхүүжүүлэхдээ и баримтаар баталгаагүй ажил гүйлгээг гаргахгүй байх,

#### **4.4.4 Шилэн данстай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Соёлын төв нь Шилэн дансны хуульд заасны дагуу цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлогын 55.1 сая төгрөгийн санхүүжилтийн ажил гүйлгээг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан журмыг зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Хууль, журамд заасны дагуу Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган холбогдох мэдээллийг үнэн мэдээлж хэвших

#### **4.4.5 Төсвийн гүйцэтгэл, төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Сумын төсөвт байгууллагын дүнгээр тогтмол зардлыг 225.4 сая төгрөгөөр төлөвлөж, төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан 220.9 сая төгрөгөөр, Төрийн сангийн зарлагын хуулгаар 208.3 сая төгрөгийн зардал гаргаж 12.5 сая төгрөгийг бусад бараа үйлчилгээний зардал гүйлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.7-д "энэ хуулийн 22.2-т заасан төсвийн ангиллын төрөл бүрээр дэлгэрэнгүй ангилал тогтоох, түүнийг төсвийн төлөвлөлт, тайлагналт, гүйцэтгэлд ашиглах журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно", 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг мөрдөн ажиллах заалтуудыг зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Эдийн засгийн ангиллын дагуу төсөвт журмын дагуу зохицуулалт хийж зардлыг санхүүжүүлэн, Төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв илэрхийлж тайлагнах

Дөргөн сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

		Хүснэгт – 6				/сая. төгрөгөөр/					
д/д	байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТТЗахирагч	3	162.6			1	1.0	1	149.1	1	12.5
2	Дөргөн ЗДТГ	6	769.5	5	721.8					1	47.7
3	Дөргөн ИТХ	6	15.8	5	9.9	1	0.9				5.0
4	Дөргөн Соёлын төв	1	60.4							1	60.4
5	Дөргөн ОНХС	4	56.5	2	20.0					2	36.5
6	Дөргөн СХС	-	6.1								6.1
<b>Дүн</b>		<b>20</b>	<b>1,070.9</b>	<b>12</b>	<b>751.7</b>	<b>2</b>	<b>1.9</b>	<b>1</b>	<b>149.1</b>	<b>5</b>	<b>168.2</b>

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

АХЛАХ АУДИТОР:

ТАЙЛАНГ БИЧСЭН:

8417140802  
04040073 0066454

У.БОЛДБААТАР

А.ЦЭЦЭГСҮРЭН

Д.НАРАНТУУЛ